



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 102 ГЛГ-БНАТАГ-12018/06-ГА
Номгон

Г

Г

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “2016, 2017 оны Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Аудитаар хийсэн биет тооллогоор эмнэлгийн эмийн сангийн нөөцийн тасгаас 3 нэр төрлийн 160,0 мянга, олгох хэсгээс 9 нэр төрлийн 942,8 мянга, нийт 1102,8 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл илүү байна.

Энэ нь Няглан бodoх бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-д заасан “Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтыг зөрчжээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх...” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Нэг. Тооллогоор илэрсэн 1,102,800 /Нэг сая нэг зуун хоёр мянга найман зуун/ төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг тооллогын үр дүнд бий болсон орлогоор бүртгэж тайланд тусгах.

Хоёр. Зөрчлийг барагдуулж, холбогдох нотлох баримтыг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох, ерөнхий няглан бодогч Д.Сайнбаяр, эмийн няглан бодогч Д.Ганхүлэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

СБИЧСЭН:
АХЛАХ АУДИТОР Б.ДОЛЖМАА
АУДИТОР П.МОНХ-ЭРДЭНЭ
АУДИТОР Б.НАРАНГЭРЭЛ
АУДИТОР Б.АЗБАЯР
БИЛД 6044
В.ДА00679007423

ЗӨВШӨӨРСӨН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Н.БАТТОГОТОХ
ЕРӨНХИЙ НЯГЛАН БОДОГЧ
Д.САЙНБАЯР
ЭМИИН НЯГЛАН БОДОГЧ
Д.ГАНХҮЛЭГ
О.ЖАРГАЛМАА

ЭМ НАЙРУУЛАГЧ

М.СЭРГЭЛЭН

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны давгуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын
газрын 2018 оны 09 дугаар сарын
11-ний өдрийн ... тоот албан шаардлагын
хавсралт

6417143544
ВЮА0067 9007423

ДД	Эмийн нэр	Илүүдсэн тоо хэмжээ	Үнийн дүн	Нийт дүн
1	Вакум теннер	1100	225	247500
2	Гордокс	1	13000	13000
3	Панангин	62	1764	109368
4	Рингер 250	50	1380	69000
5	Уян зүү	230	803	184690
6	Цераксон 500 мг/4 мл	1	8605	8605
7	Церуулан	163	770	125510
8	Цефазолин 1 ед	69	800	55200
9	Экватор 20 мг-10 мг	1	1250	1250
10	Шприц 10	124		128712
12	Лафербион лаа	20	5500	110000
13	Төвийн венийн кататер	2	25000	50000
Нийт дүн				1102835



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2018 оны 09 сарын 14 өдөр

Дугаар 103 ГАГ-БНАТАГ-12181-06-7A Номгон

Г Зөрчил арилгуулах тухай Т

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “2016, 2017 оны Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн эмийн зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авалтын байдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

2018 оны 08 дугаар сард ЦССҮТ-д 400 ширхэг цусны хүүдийний төлбөрт 6400,0 мянган төгрөгийг шилжүүлж, бараа материалыг хүлээн аваагүй атлаа нөөцийн тасагт орлогоор бүртгэсэн, 336,6 мянган төгрөгийн үнэ бүхий 200 ширхэг сукасаметонин уусмал тооллогоор илүүдсэн бөгөөд нягтлан бодох бүртгэлд авлага, өглөгийг тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-д заасан “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4-д заасан “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ...” гэсэн заалтыг зөрчжээ.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.7-д

"Хууль, тогтоомж зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх..." гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ** нь:

Нэг. Аудитын тооллогоор илүүдсэн болон дутагдсан 6,736,600 /Зургаан сая долоон зуун гучин зургаан мянга зургаан зуун/ төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг нягтлан бодох бүртгэлийн бичилтээр залруулж бүртгэл тайланд тусгах.

Хоёр. Зөрчлийг барагдуулж, холбогдох нотлох баримтыг 2018 оны 09 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Н.Баттогтох, ерөнхий нягтлан бодогч Д.Сайнбаяр, эмийн нягтлан бодогч Д.Ганхүлэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГЫГ

БИЧСЭН
АХЛАХ АУДИТОР *Б.ДОЛЖМАА*
АУДИТОР *П.МӨНХ-ЭРДЭНЭ*

6417143544
ВЮА0067 9007423

ЗӨВШӨӨРСӨН:
БАЯНХОНГОР АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА →
Н.БАТТОГОХ
ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ
Д.САЙНБАЯР
ЭМИЙН НЯГТЛАН БОДОГЧ
Д.ГАНХҮЛЭГ
О.ЖАРГАЛМАА

Биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ

¹ Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ